


**МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ СПОРТЫН
ХОРООНЫ ДҮРЭМ**

Нэгдүгээр зүйл.
Байгууллагын нэр, байршил



1.1. Байгууллагын нэр нь монгол хэлээр **Монголын Үндэсний Спортын Хороог**, товчилсон нэр нь “МУСХ” (цаашид энэ дүрмэнд товчлолыг хэрэглэнэ), англи хэлээр “Committee of Mongolian National Sports” товчилсон нэр нь CMNS, регистрийн дугаар 8233799

1.2. МУСХ нь өөрийн билэгдэл, тэмдэг, данс, албан бичгийн хэвлэмэлхуудастай байна.

1.3. Байршил: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, кредит банк, 4 давхар, 402 тоот

1.4. Байгуулагдсан он, сар, өдөр: 2017 оны 1 дугаар сарын 17 –ныөдөр

1.5. Монголын Үндэсний Спортын Хороог үүсгэн байгуулагчид:

д/д	Овог нэр	Регистрийн дугаар	Төлөөлөх гишүүн үндэсний спортын холбоо
1	Цэрэндашдоржийн Магалжав	Фа77100215	Монголын Үндэсний Бөхийн Холбоо
2	Цэвээнжавын Дуламсүрэн	УС61012513	Монголын Үндэсний морин уралдаан, уяачдын холбоо
3	Бадарчийн Хүрэлбаатар	ЦЖ72121216	Монголын Үндэсний Харваачдын холбоо
4	Шаравдоржийн Отгонбаяр	ЕЭ69061471	Монголын Шагайн Харвааны холбоо
5	Насан-Очирын Эрдэнэ-Очир	ХЖ79101036	Монголын Үндэсний мөсөн шагайн холбоо
6	Амарбаярын Гомбодорж	БД80042819	Монголын мөсөн сурын холбоо
7	Авирмэдийн Эрдэнэбаяр	ХЕ72121717	Монголын тэмээн поло, спорт уралдаан, аялалын холбоо
8	Буянтын Энхсайхан	БЮ82040910	Монголын өвөг урианхай сурын холбоо
9	Машбатын Зоригт	ХП61072718	Монголын Уламжлалт харваачдын холбоо
10	Бүмүүгийн Амарсайхан	ЖЛ59030811	Буриад сурын холбоо
11	Долгоржавын Эрдэнэхуяг	ХН70021171	Монголын Үндэсний жороо морин спортын холбоо
12	Шавирай Цогтхүү	ЧЖ70050779	Монголын морьт харваачдын холбоо
13	Тайвангийн Арслан	КЮ53050315	Ширээний шагайн спорт, тоглоомын холбоо
14	Дархижавын Отгонбаяр	ЧГ69040911	Монголын Үндэсний бие хамгаалах урлагийн холбоо

1.6. Монголын Үндэсний спортын хорооны үүсгэн байгуулагч нь гишүүн үндэсний спортын холбооны ерөнхийлөгч эсхүл тэргүүн байх бөгөөд тухайн холбооны удирдлага өөрчлөгдсөн тохиолдолд энэхүү хорооны үүсгэн байгуулагчаас гарч, шинээр сонгогдсон ерөнхийлөгч эсхүл тэргүүн түүний оронд үүсгэн байгуулагчид нэмж орно.

1.7. Монголын Үндэсний спортын хорооны үүсгэн байгуулагчийг тухайн

холбооны албан тоотоор орох, гарахыг шийдвэрлэнэ.

Хоёрдугаар зүйл. Үйл ажиллагааны үндсэн зорилго

21. Үндэсний спортоор дамжуулан монгол хүнд Монгол ахуй, нүүдэлчдийн соёл, ёс суртахуун, гоо зүй, бие бялдарын хүмүүжил олгох, хурд хүч, сэтгэн бодох чадвар, тэвчээр хатуужилтай болгох, иргэдийн чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх, хувь хүний ажиллах чадвар, бүтээмжийг дээшлүүлэх, үндэсний спортын төрлүүдийг хадгалах, хамгаалах, хөгжүүлэх, үндэсний хөтөлбөр батлуулан хэрэгжүүлэхэд зорилго оршино.

22. Монгол түмний өвөрмөц соёл, зан заншил, уламжлалаа хадгалах, хойч үедээ өвлүүлэхийн тулд үндэсний спортын төрлүүдийг бүхий л талаар хөгжүүлж, олон улсын хэмжээнд сурталчлан дэлгэрүүлнэ.

23. Аялал жуулчлалыг хөгжүүлэх, үндэсний спортын соёлын өвийг түгээх, Дэлхий дахинд сурталчилах зорилгоор үндэсний соёл спортын наадам, арга хэмжээнүүдийг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран тогтмол зохион байгуулна.

24. Үндэсний спортын холбоодын бие даасан, мэргэжлийн үйл ажиллагааг дэмжиж Үндэсний их баяр наадам, улс, олон улсын томоохон арга хэмжээ, наадмуудыг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран болон төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэх зарчмын дагуу дангаар хариуцан ажиллана.

Гуравдугаар зүйл. Үйл ажиллагааны үндсэн зарчим

3.1. МҮСХ нь Монгол улсын Үндсэн хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг хүндэтгэн мөрдөж, үндэсний спортыг үндэсний болон олон улсын хэмжээнд хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх зорилго бүхий үндэсний спортын холбоодыг /байгууллагуудыг/ нэгтгэсэн гишүүнчлэлтэй, нийгэмд үйлчилдэг, ашгийн төлөө бус төрийн бус байгууллага байна.

3.2. МҮСХ нь монгол түмний соёлын биет болон биет бус өв болох үндэсний спортын төрлүүдийг түүхэн уламжлал, заншил, дэг жаягийг нь сахин хадгалж, орчин үеийн нөхцөлд нийцүүлэн, шинжлэх ухааны ололтод тулгуурлан төр, засгийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдтэй хамтран ажиллах замаар хөгжүүлнэ.

3.3. МҮСХ нь улс төр, шашин, бизнесийн аливаа дарамт шахалт, нөлөөнөөс ангид байж, гишүүн байгууллагуудыхаа эрх ашгийг бүрэн хамгаалсан бие даасан үйл ажиллагааг явуулна.

3.4. МҮСХ нь үндэсний спортын төрлүүдийг монголчуудын соёлын үнэт өвийн хувьд өвөрмөц онцлог, уламжлалт дэг жаягийг нь хадгалж, хойч үедээ өвлүүлэн үлдээнэ.

3.5. НҮБ-ын ЮНЕСКО-ийн “Бие бялдрын боловсрол, идэвхтэй хөдөлгөөн, спортын олон улсын харти”, Уламжлалт спорт наадмын Олон улсын Зөвлөлийн дүрэм болон үндэсний спорт, соёлын өвийг хадгалан хамгаалах тухай бусад олон улсын баримт бичигт заасан зарчимд нийцүүлж ажиллана.

Дөрөвдүгээр зүйл.

Үйл ажиллагааны үндсэн чиглэл

41. МҮСХ нь үндэсний спортыг хөгжүүлэх талаархи төрийн бодлого, үзэл баримтлал, салбар яам, агентлагын хөтөлбөр, арга хэмжээ, үйл ажиллагааг боловсруулах болон хэрэгжүүлэхэд тал бүрийн дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах, үндэсний спортын аливаа маргааныг зөв талаас шийдвэрлүүлэх

42. МҮСХ нь гишүүн байгууллагуудаа нэгдсэн бодлого зохицуулалтаар хангах

43. МҮСХ нь аялал жуулчлалыг хөгжүүлэх, өв соёлоо олон нийтэд таниулан сурталчилах, түгээн дэлгэрүүлэх, хойч үедээ өвлүүлэх, сэргээн хөгжүүлэх зорилгоор үндэсний спорт, соёлын томоохон арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулах

44. МҮСХ нь үндэсний өв соёл болох үндэсний спортын төрлүүдийг НҮБ-ын ЮНЕСКО-ын биет болон биет бус соёлын өвд бүртгүүлэх ажлыг зохион байгуулж дэмжиж ажиллах, дүрмийн зорилгын хүрээнд Олон улсын байгууллагад элсэх, олон улсын үйл ажиллагаанд оролцох

45. Үндэсний спортын наадам, соёлын арга хэмжээ, тэмцээн, уралдааныг зохион байгуулах нийслэл, дүүрэг, аймаг, сум, байршлыг сонгон шалгаруулах, эрх олгох, зохион байгуулагдах спортын төрлүүдийг тогтоох

46. МҮСХ нь үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх төр засгийн бодлого, үйл ажиллагааны хүрээнд үндэсний спортын хэрэгсэлийн үйлдвэрлэлийг уламжлалт болон дэвшилтэд технологи ашиглан хөгжүүлэх

47. МҮСХ нь үндэсний спортын томоохон арга хэмжээг олон улсад болон монгол туургатны хүрээнд зохион байгуулж өв соёлоо сурталчилах

48. МҮСХ нь үндэсний спорт, соёлыг хөгжүүлэх санг байгуулж, маркетингийг хөгжүүлэх, санхүүгийн шинэ эх үүсвэр бий болгох, тухайн үйл ажиллагаанд хандивлагчидтай хамтран ажиллах

49. МҮСХ нь үндэсний спортын төрлүүдийн үүсэл хөгжил түүхийг судлах болон өнөөгийн нөхцөлд нийцүүлэн шинжлэх ухааны ололт амжилтанд тулгуурлан хөгжүүлэх чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг зохион байгуулна.

410. МҮСХ-ны гишүүд болон үйл ажиллагааны хөгжилд хувь нэмэр оруулсан хувь хүн, байгууллагыг төр засгийн шагналд нэр дэвшүүлэх буюу МҮСХ-ны шагналаар шагнаж урамшуулах

411. МҮСХ-ны “Үндэсний спортын ордон” барьж, байгуулах ажлыг зохион байгуулах

412. МҮСХ нь үндэсний спортын төрлүүдийг ерөнхий боловсролын болон их дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт оруулах

413. МҮСХ-ны гишүүн холбоод нь тухайн спортын төрлөөр мэргэшсэн сургагч багш нарыг бэлтгэх, шавь сургалтыг эрхлэх, хөгжүүлэх

414. МҮСХ нь зорилгоо хэрэгжүүлэхдээ Монгол улсын эрх зүйн актууд болон энэхүү дүрмээр хориглоогүй бусад ажлуудыг хийнэ.

Тавдугаар зүйл.

МҮСХ-ны удирдлагын тогтолцоо

5.1. МҮСХ-ны удирдлагын тогтолцоо, бүтэц нь Бүх гишүүдийн хурал, Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, Удирдах зөвлөлийн хурал, Ерөнхий нарийн бичгийн

дарга, нарийн бичгийн дарга, гишүүн холбооны удирдлагаас бүрдэнэ.

Зургадугаар зүйл. МҮСХ-ны Бүх гишүүдийн хурал

6.1. МҮСХ-ны үйл ажиллагааг удирдах дээд байгууллага нь бүх гишүүдийн хурал байна. Гишүүдийн хурал нь 4 жил тутамд хуралдана.

6.2. Бүх гишүүдийн хурал хуралдах хугацааг 3 сараас доошгүй хугацааны өмнө зарлана. Хэлэлцэх асуудлыг 30-аас доошгүй хоногийн өмнө гишүүн үндэсний спортын холбоодод мэдэгдэн бүх гишүүдийн хурал эхлэхээс 14-с өөс доошгүй хоногийн өмнө Ерөнхий нарийн бичгийн даргад ирүүлсэн гишүүн холбоодын саналыг хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулна.

6.3. Бүх гишүүдийн хурал нь гишүүн үндэсний спортын холбоодын 3/4-аас дээш хувь оролцсон тохиолдолд хүчинтэйд тооцно. Бүх гишүүдийн хурлын шийдвэрийг санал хураалтад оролцогсодын олонхийн саналаар гаргана.

6.4. Бүх гишүүдийн хуралд гишүүн холбоод тус бүрээс 3 төлөөлөгч оролцоно.

6.5. Бүх гишүүдийн хуралаар дараахь асуудлыг хэлэлцэнэ.

Үүнд:

6.5.1. Үйл ажиллагааны тайлан, хянан шалгах зөвлөлийн тайлан

6.5.2. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах

6.5.3. МҮСХ-ны Ерөнхийлөгч чөлөөлөх, сонгох

6.5.4. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах

6.5.5. Хяналтын Зөвлөлийн бүрэлдэхүүн, гишүүдийг сонгох

6.5.6. МҮСХ-ны үүсгэн байгуулах гишүүнийг оруулах, эсхүл гишүүн

оруулах эрхийг удирдах зөвлөлд шилжүүлэх

6.6. Хурал эхлэхээс 14 хоногийн өмнө МҮСХ-ны гишүүн байгууллагаас хүндэт ерөнхийлөгч болон Удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлнэ.

6.7. Ерөнхийлөгч болон Удирдах зөвлөлийн гишүүдийн сонгуулийг нууц санал хураалтаар явуулна. Хүндэт ерөнхийлөгчид нэр дэвшигч нийт саналын 50-иас дээш хувийг авсан тохиолдолд сонгогдсонд тооцогдоно. Хэрэв аль ч нэр дэвшигч 50-иас дээш хувийн санал аваагүй тохиолдолд хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийг үлдээж дахин санал хурааж шийдвэрлэнэ.

6.8. Хурлын гишүүдийн 3/4-аас доошгүй хувь нь гарын үсэг зурж бичгээр санал гаргасан тохиолдолд ээлжит бус бүх гишүүдийн хурлыг хуралдуулна.

Долдугаар зүйл.

Удирдах зөвлөл

7.1. Удирдах зөвлөл нь бүх гишүүдийн хурлын хоорондох МҮСХ-ны үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

7.2. Удирдах зөвлөл нь дараах бүрэлдхүүнтэй байна. Үүнд:

1. Ерөнхийлөгч 1

2. Дэд ерөнхийлөгчийн тоог Удирдах зөвлөл батална.

3. Удирдах Зөвлөл нь гишүүн холбоо тус бүрээс албан тоотоор 1 гишүүн,

үндэсний спортын чиглэлээр мэргэшсэн, салбарын эрдэмтэд, судлаачдаас бүрдсэн 10 хүртэл гишүүнээс бүрдэнэ.

7.3. Удирдах зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүнийг бүх гишүүдийн хурлаас 4 жилийн хугацаагаар дүрмээр батална.

7.4. Бүх гишүүдийн хурлын чөлөөтэй хугацаанд Удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх, гишүүн үндэсний спортын холбооны хүсэлтийн дагуу өөрчлөх эрхтэй.

7.5. Удирдах зөвлөлийн хурал нь удирдах зөвлөлийн гишүүдийн олонхи ирснээр хүчин төгөлдөр болж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын дэмжиснээр шийдвэр, тогтоол хүчин төгөлдөр болно.

7.6. МҮСХ-ны үйл ажиллагааг явуулахдаа энэхүү дүрмийн 4-р зүйлд заасан чиглэлээр аливаа шийдвэр, тогтоолыг олонхын саналаар шийдвэрлэнэ.

7.7. Гишүүдээс бүрдсэн комисс, ажлын хэсэг байгуулах, хийх ажил, чиг үүргийг батлах, хянах, зогсоох, тараах эрхтэй.

Наймдугаар зүйл.

Ерөнхийлөгч

8.1. МҮСХ-ны Ерөнхийлөгчийг бүх гишүүдийн хурлаас төлөөлөгчдөөс нэр дэвшүүлэн олонхын саналаар 2 жилийн хугацаатайгаар сонгоно. Ерөнхийлөгч нь 1 удаа улиран сонгогдож болно.

8.2. МҮСХ-ны Ерөнхийлөгч дараах эрхтэй.

- 8.2.1. Дэд ерөнхийлөгчийг нэр дэвшүүлж Удирдах зөвлөлөөр батлуулах
- 8.2.2. Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох
- 8.2.3. МҮСХ-г гадаад, дотоодод бүрэн төлөөлөх
- 8.2.4. Бүрэн эрхийн хүрээнд шийдвэр гаргах
- 8.2.5. Бүх гишүүдийн хурал, Удирдах зөвлөлийн хурлын үйл ажиллагаа, түүний хуралдааныг удирдах
- 8.2.6. МҮСХ-ийг төлөөлөн төрийн байгууллагатай харилцах

8.3. Хэрэв ерөнхийлөгч албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд /огцорсон, өөрийн хүсэлтээрээ чөлөөлөгдсөн, эрүүл мэндийн байдлаас цаашид ажиллах боломжгүй болсон, нас барсан бол үлдсэн хугацаанд/ Удирдах Зөвлөлийн хурлаар сонгогдсон аль нэг дэд ерөнхийлөгч нь үлдэх бүрэн эрхийн хугацаанд Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Есдүгээр зүйл.


Ерөнхий нарийн бичгийн дарга

9.1. Ерөнхийлөгчийн томилсон Ерөнхий нарийн бичгийн дарга нь ажлын албатай байна. МҮСХ-ны дүрэмд заасан үйл ажиллагааг байнгын тогтвортой хэрэгжүүлэх бүрэн эрхтэй байна.

9.2. Ерөнхий нарийн бичгийн дарга нь МҮСХ-ны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан ажиллах орон тооны ажилтан байна.

9.3. МҮСХ-ны үйл ажиллагаа, санхүүгийн тайлан бүх гишүүд болон нийтэд ил тод байх бөгөөд энэхүү үүргийг Ерөнхий нарийн бичгийн дарга хэрэгжүүлнэ.

9.4. Ерөнхий нарийн бичгийн дарга нь бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх



стратеги төлөвлөгөө, тухайн жилд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг удирдах зөвлөлийн хурлаар батлуулах, хэрэгжүүлэх, тайлагнах үүрэгтэй.

**Аравдугаар зүйл.
Хяналтын Зөвлөл**

10.1. Хяналтын Зөвлөлийг /цаашид ХЗ гэж товчилно/ 3 хүний бүрэлдхүүнтэйгээр МҮСХ –ны бүх гишүүдийн хурлын төлөөлөгчдөөс нэр дэвшүүлж дөрвөн жилийн бүрэн эрхийн хугацаатай сонгоно.

10.2. Хяналтын зөвлөл нь бүрэлдхүүнээсээ даргаасонгоно.

10.3. Хяналтын зөвлөл дараахь үйл ажиллагаанд хяналт тавьгажиллана.

10.3.1. МҮСХ-ны дүрмийн биелэлт, шийдвэр, тогтоолд

10.3.2. Ерөнхийлөгчийн болон Удирдах зөвлөлийн шийдвэр нь МҮСХ-ны дүрэм, хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх

10.3.3. МҮСХ-ны ажлын алба, ерөнхий нарийн бичгийн даргын үйл ажиллагаа, санхүү

**Арваннэгдүгээр зүйл.
Гишүүн үндэсний спортын холбоо**

11.1. Гишүүн үндэсний спортын холбоо нь МҮСХ-ны дүрмийг хүлээн зөвшөөрч өөрийн дүрэм болон МҮСХ-ны дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулах, Монгол Улсад тухайн үндэсний спортын төрлийн нэгтөрийн бус байгууллага байна.

11.2. МҮСХ-нд гишүүнээр элсэх тохиолдолд тавигдах шаардлага хангасан үндэсний спортын хороо нь бүрдүүлэх материалыг хангаж, хүсэлтээ илгээх үүрэгтэй.

11.3. Гишүүн үндэсний спортын холбоо нь дараах үндсэн үүрэгтэй.

11.3.1. Жил бүр улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах

11.3.2. МҮСХ-ны Удирдах Зөвлөлөөс тогтоосон татвараа жил бүртөлөх

11.3.3. Үйл ажиллагааны тайлан жил бүргаргах

11.3.4. Тухайн спортынхоо чиглэлээр бодит үйл ажиллагааг тасралтгүй явуулах хууль эрх зүй, эдийн засгийн чадамжтай байна

11.3.5. Удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийг гишүүн холбоод үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.

11.2. Дүрмийн 11.2-оор хүлээсэн үүргээ 2 жилийн хугацаанд биелүүлээгүй гишүүн үндэсний спортын холбоо нь МҮСХ-ны гишүүнчлэлээс хасагдана.

11.3. Гишүүнчлэлээс хасагдсан үндэсний спортын холбоо нь дүрмийн 11.2-т заасан үүргээ 2 жил биелүүлсэн тохиолдолд гишүүнчлэлээ сэргээж болно.

**Арванхоёрдугаар зүйл.
Хөрөнгө, санхүү**

12.1. МҮСХ-ны хөрөнгө санхүү дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

12.1.1. Улсын төсвөөс олгосон санхүүжилт

12.1.2. Гадаад, дотоодын байгууллага, хувь хүмүүсээс МҮСХ-нд хандивласан техник тоног төхөөрөмж, хэрэглэл материал, эд хөрөнгө, үндэсний болон гадаадвалот,

- 12.1.3. Спортын үйл ажиллагаанд зориулж байгууллага, иргэдээс МҮСХ-нд эзэмшүүлсэн барилга байгууламж, хөрөнгө оруулалт,
- 12.1.4. Спортын маркетинг, мөнгөн хонжворт сугалаа, дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого,
- 12.1.5. Үйл ажиллагааны явцад бүрдсэн архивын материал, олон улсын спортын байгууллагын баримт бичиг,
- 12.1.6. МҮСХ-ны гишүүн болон хүлээн зөвшөөрсөн байгууллагын элсэлтийн ба жилийн татвар
- 12.1.7. Бусад орлого
- 12.2. МҮСХ-ны хөрөнгө санхүүг үндэсний спортыг хөгжүүлэх үйл ажиллагаанд зориулна.
- 12.3. МҮСХ нь өөрийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй.
- 12.4. МҮСХ нь дэргэдээ спорт сугалааны оператор ба үндэсний спортын хэрэгслэлийн үйлдвэр, дэлгүүр зэрэг байгууллагыг Төрийн бус байгууллагын хуульд нийцүүлэн ажиллуулж болно.

**Арван гуравдугаар зүйл.
Хороог татан буулгах**

- 13.1. Зөвлөл нь өөрийн дүрэмд заасан зорилгоо бүрэн хэрэгжүүлж дууссан болон цаашид үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх шаардлагагүй гэж үзвэл бүх гишүүдийн хурлын 3/4-аас дээш хувийн саналыг үндэслэн шийдвэр гаргана.
- 13.2. Зөвлөл татан буугдсан тохиолдолд эд хөрөнгийг ижил төстэй зорилго бүхий байгууллагад шилжүүлэх бөгөөд ийм байгууллага байхгүй бол зөвлөлийн зорилгонд нийцсэн үйл ажиллагаанд зарцуулна.

**Арван дөрөвдүгээр зүйл.
Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах**

- 14.1. Нэмэлт өөрчлөлт оруулахдаа Удирдах зөвлөлийн 3/4 хувийн саналаар дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж болно. Дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлт оруулах төслийг ерөнхий нарийн бичгийн дарга боловсруулж Удирдах зөвлөлийн хурлаар батласнаар хүчин төгөлдөр болно.
- 14.2. Нэмэлт өөрчлөлтийг бүртгүүлэх ажлыг ерөнхий нарийн бичгийн дарга хариуцна.

УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ СПОРТЫН ХОРООНЫ
БҮХ ГИШҮҮДИЙН II ХУРАЛДААН

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ